



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1972 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын районы гүйцэтгэх захиргааны талаар авах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд зөвшөөрөх нь:

а/системийнхээ орон тоонд багтаан, Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчны районы гүйцэтгэх захиргаанд хот тохижуулах хэлтэс байгуулах;

б/районы төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн орон нутгийн орлогын 10 хүртэл хувийг районы гүйцэтгэх захиргаанд өгч байхыг тус тус зөвшөөрсүгэй.

2. Социалист уралдаанд шалгарсан тэргүүний байгууллага, орон сууц гудамжны хороо, хүмүүсийг урамшуулахад зориулан, 3000-4000 хүртэл төгрөгийг районы жилийн төсөвт оруулан олгож байхыг Сангийн яам /н.МОЛОМ/-д даалгасугай.

3. Районы гүйцэтгэх захиргааны дуудлагын автомашины өдөрт явах километрийн хэмжээг өвлийн улиралд 60 км, зуны улиралд 70 км-ээр тогтоосугай.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
нэгдүгээр орлогч дарга

Д.МАЙДАР

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

Б.БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

Ш. Ринчин /Ш.РИНЧИН/

